



Хааны Зүүд

МАГТААЛ ХҮНДЛЭЛ Бид Их Эзэнийг магтан хүндлэхдээ баяртай байдаг.

Унших Зүйл

Даниел 2:1-28,46-49; *Зөнчид ба Хаад*, х. 491-502.

Цээжлэх Ишлэл

"Их Эзэний ивээлийн тухай сайн мэдээг би хүмүүст хэлмээр байна" (Үйлс 20:24).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Бусад хүмүүс Их Эзэний тухай мэдэж Түүнийг алдаршуулахад тусалж чадна гэдгээ мэдэх болно.

Бусдыг Их Эзэний тухай мэдээсэй гэсэн хүсэл эрмэлзэлтэй болно.

Их Эзэний тухай хүмүүст ярих болно.

Гол Санаа



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Небухаднезар хаан Их Эзэнээс онцгой зүүд авч мэргэдийг дуудан зүүдээ тайлбарлуулах гэсэн боловч тэд чадсангүй. Тэгээд хаан нутагтаа байгаа бүх мэргэн хүмүүсийг цаазаар ав хэмээн тушаал өгчээ. Даниел тэнд байгаагүй болохоор, үйлчлэгч явж Даниелыг олж түүнийг хааны өмнө авчирав. Даниел Их Эзэнтэй ярилцах цаг гуйхад хаан зөвшөөрч Даниел 3 найзынхаа хамт Бурханд залбирахад Бурхан түүнд хааны зүүдний утгыг тайлахад тусалжээ. Даниел эхлээд Их

Эзэнийг магтан, дараа хаанд Израилийн хааны тухай ярьж өгөв. Даниелын Их Эзэн бол цорын ганц үнэн Эзэн Бурхан гэдгийг сонсоод хаан ихэд гайхширлаа.

Энэ бол магтаал хүндлэлийн тухай хичээл

Бид хүмүүсийн өмнө зогсоод тэдэнд Их Эзэний тухай ярьж сайн мэдээг дамжуулах юм бол тэр нь яг Даниелын хийсэн шиг Их Эзэнийг магтан хүндэлж буй хэрэг юм.

ЗУРГАА

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Сайн Мэдээг Дамжуул</i> <i>Б. Тоог Таа</i>	байхгүй байхгүй
* Залбирал ба Магтаал*	10 минут	63-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	өгүүлэгч, Библийн тухайн үеийн хувцастай хоёр том хүн, хөнжил ба дэр
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>А. Бидний Магтах Арга Зам</i> <i>Б. Есус Бол Миний Найз</i>	наалддаг тууз, мөчир эсвэл саваа мод, нэхмэлийн утас эсвэл чулуу, цаас, зураг байхгүй
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Хаалга Тогших</i>	хаалганы загвар зураг (142-р хуудас), цаас, өнгийн харандаа, товч, цавуу

Багшийн Баяжуулалт

"Иудейчүүдийг харвал, дэлхийн хамгийн хүчирхэг гүрний эзэн хааны оршихуй дотор, тайван амгалан мэт байв. Эзэн хаан анхныхаа яриагаар л, өөрийг нь хүндэтгэхийг татгалзаж, харин Бурханыг бүхий л мэргэн ухааны эх булаг хэмээн өргөмжилж байсан (*Зөнч ба Хаад*, х. 494).

"Даниел болон түүний нөхдийг Вавилоны хаант улсын үйлчлэлд орсны дараахан, Небухаднезар хаан сүнс төөрөлдөж, нойр сэргэмээр сонин зүүд зүүдэлжээ. Гэвч хэдийгээр хааны оюун ухаанд энэхүү зүүд гүнзгий нөлөөлсөн ч, үүнийг боломжгүй гэж үзэн, сэрээд өөрийн мэргэдээ дууджээ.

"Тэрээр мэргэдийнхээ зайлсхийсэн,

сэжиг бүхий хариултад сэтгэл ханасангүй учир ... тэд ... түүнд туслах хүсэлгүй мэт харагдсан аж, ингээд хаан нэг талаас эд хөрөнгө, нэр алдар амлаж, нөгөө талаас цаазаар авах тушаал гарган, бүх мэргэн хүмүүсийг зөвхөн түүний зүүдийг тайлбарлах биш, мөн зүүдийг тэр чигээр нь ярьж өгөхийг тушаан дууджээ" (*Зөнч ба Хаад*, х. 491, 492).

Бид өдөр бүрийн харилцаандаа, Бурханыг итгэмжтэйгээр өргөмжилдөг үү? Манай Шаббат хичээлийн хүүхдүүд бидний хийж, ярьж байгаа бүхнээс Христийн хайрыг олж харж чаддаг болов уу?

Өрөөний Зохион Байгуулалт

Тавдугаар хичээлийг хараарай.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Сайн Мэдээг Дамжуул

Хүүхдүүдийг 5 эсвэл 6-аар нь нэг бүлэгт оруулан бүлэг тус бүрийг нэг эгнээ болгон зогсоо. Хэлэх: **Зарим хүмүүс Есүсийн тухай мэддэггүй гэдгийг та нар мэдэх үү? Үүнд итгэж чадах уу? За, надад сайн мэдээ байна.** Бүлэг тус бүрийн эхний хүүхдэд доорх үгийг шивнэж хэлбэл хүүхдүүд цааш дамжуулан шивнэж хэлээд суудалдаа суух ёстой.

Есүс чамд хайртай.

Есүс чиний найз байхыг хүсэж байна.

Есүс чамайг онцгой нэгэн гэж бодож байна.

Бүх хүүхдүүд суусны дараа бүлэг тус бүрээс сайн мэдээ нь юу байсныг нь асуугаад эхний хүүхдийг солин бүх хүүхэд сайн мэдээг хамгийн түрүүнд сонсож чадсаныг нь дараа дуусгаарай.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах цаг өгөөрэй: **Сайн мэдээг сонсоход хөгжилтэй байсан уу? Мөн үүнийг дамжуулахад хөгжилтэй байсан уу? Бид бусдад Есүсийн тухай ярьвал Тэр маш их баярладаг гэдгийг та нар мэдэх үү? Есүс өөрт нь хайртайг хүн бүр мэдээсэй гэж хүсэж байна. Өнөөдөр Шаббат хичээл дээр хийсэн шигээ сайн мэдээг та нар хүмүүст тараавал Есүсийг магтан хүндэлж буй хэрэг юм. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол Даниелын хаанд хэлсэн зарим сайн мэдээний тухай юм. Өнөөдрийн хичээлийн гол санаа бол:**



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Тоог Таа

Гурван хүүхэд бүрийг нэг том хүнтэй нэг бүлэг болгоорой. Хэлэх: **Бид одоо таавар тоглоом тоглох гэж байна. Том хүмүүсийг би нэгээс арвын хооронд ямар нэгэн тоо дотроо бодоосой гэж хүсэж байна. Одоо том хүний дотроо бодсон тоог хүүхдүүд ээлжлэн таах болно. Хүүхэд бүрийг ээлжлүүлэн тоог таалгаарай.**

Бататгах нь

Хэлэх: Зөв тоог таахад амархан байсан уу? Хэцүү байсан уу? Хэн нэгэн хүний бодож байгааг мэддэг хүн байдаг болов уу? Мэддэг ганцхан хүн байдаг бол тэр хэн бэ? Тийм ээ, зөв. Тэр бол Их Эзэн. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол зүүдэлсэн зүүдээ санахгүй байгаа нэгэн хааны тухай юм. Зөвхөн Их Эзэн л хааны зүүдэлсэн зүүдийг мэдэж байсан бөгөөд хаанд юу гэж хэлэхийг нь Даниелд хэлж өгсөн юм. Өнөөдрийн гол санаа:



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нохорлол

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

"Адислал" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 302*)

"Бяцхан хүү минь, болгоомжтой байгаарай" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 307*)

"Сайн мэдээг хуваалц" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 312*)

"Та хэлэх ёстой" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 315*)

"Миний бяцхан гэрэл" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 313*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс ямар нэгэн түүх ашиглаарай. Асуух:

Өнөөдрийн үзсэн түүхэнд хүмүүс Их Эзэнийг хэрхэн магтан хүндэлсэн бэ? Шаббат өдрийн үйл ажиллагааг бүү хязгаарла.

Хандив

Хэлэх: **Бид өргөлөө авчирснаараа Их Эзэнийг алдаршуулдаг. Учир нь хүмүүс Түүний тухай мэдэх болно.**

Залбирал

Хэлэх: **Бид Их Эзэнтэй янз бүрийн аргаар ярилцаж болно. Одоо бүгдээрээ Их Эзэнд зориулж дуу дуулцгаая.** "Их Эзэн бол хамгийн сайн нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 128*) -с зарим мөрөнд нь өөрчлөлт оруулан дуулаарай. *Тэнгэрт буй Их Эзэндээ өвдөг сөгдөн залбирцгаая Их Эзэн миний залбирлыг сонсож байгаа. Тэр үг бүрийг минь сонсож байгаа.*

*Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

- Хэрэгтэй зүйл:**
- өгүүлэгч
 - Библийн тухайн үеийн хувцастай 2 том хүн
 - хөнжил ба дэр

*Гэрлээ бүдгэрүүлээд
Небухаднезар хаан орондоо
ороод хөнжил нөмрөн унтаж буй
дүр үзүүлнэ. Хааны түүхийг
ярьж байх хооронд Даниел ирж
ангийнхны ард хэвтэнэ.*

Өгүүлэгч: Өнөөдрийн бидний өгүүлэх түүх олон жилийн тэртээ болсон юм. Маш хүчирхэг нэгэн хаан Небухаднезар маш том оронд амрьдардаг бөгөөд олон зарц, мэргэдтэй байлаа.

Мэргэдүүд нь түүнд ярвигтай асуудлыг шийдэхэд нь мөн зүүднийх нь утгыг тайлж өгдөг байжээ. Нэгэн шөнө хаан ихэд сонин зүүд зүүдлэв. *[Хаан орондоо хөрвөөж байгаад сэрэх].* Хөөх, хаан сэрчихлээ. Түүнээс бүгдээрээ түүхээ ярьж өгөхийг нь асууя.

Хаан: Өө, сайн уу? Өглөөний мэнд.

Өгүүлэгч: Небухаднезар хаантаан, та бидэнд зүүднийхээ тухай ярьж өгөхгүй юу?

Хаан: Тэгэлгүй яахав. Би хэдэн өдрийн өмнө өдөр бүр унтдаг шигээ л орондоо унтахаар хэвтсэн. Би зүүд зүүдэлвэл тийм ч удаан унтаж чаддаггүй л дээ. Та нар зүүд гэж юу болохыг мэдэх үү? Энэ нь яг л зүүдэндээ зураг харж байгаа юм шиг. Гэвч заримдаа тэр зураг нь сайхан, заримдаа муухай байдаг.

Би нэгэн маш сонин зүүд зүүдэлсэн юм. Ямар утгатай болохыг нь ч ойлгоогүй. Эцэст нь би босоод зарц нараараа мэргэдүүдээ дуудуулан тэднээс юу зүүдэлснээ асуухад тэд зүгээр л тааж байлаа. Учир нь хэрвээ тэд хэлж чадахгүй бол маш том асуудалд унах байв.

Тэгэхээр нь би улсын бүхий л мэргэн хүмүүсийг дуудуулахад зарц нар маань Даниелыг авчирлаа. Тэгээд Өө, хүлээгээрэй. Даниел их ойрхон байх шиг байна. Бүгдээрээ түүнээр

үлдсэн түүхийг яриулъя. Хэн нэгэн миний туслагч байж чадах уу? Тэр тэнд байна. *[Өрөөний хойд тал руу заах].*

Даниел: Өө, сайн байцгаана уу?

Хаан: Даниел, чи найзуудад маань миний зүүдний тухай ярьж өгөхгүй юу?

Даниел: За тэгье хаантаан. *[Хааны хажууд суух].*

Цэргүүд над дээр ирэхэд би унтаж байлаа. Хааны мэргэдүүд нь хаанд юу зүүдэлснийг нь хэлж чадаагүй учраас чи их том асуудалтай болчихлоо гэж тэд надад хэлсэн. Би ч хааны юу зүүдэлснийг нь мэдэхгүй байсан бөгөөд харин Их Эзэн мэдэж байгаа гэдгийг мэдэж байсан. Их Эзэн бүгдийг мэддэг. Би цэргүүдээс хаантай уулзаж болох эсэхээ асуухад тэд намайг түүн дээр аваачсан юм.

Хаан: Даниел надаас Их Эзэнтэй ярилцах цаг асуугаад Их Эзэн бүгдийг мэддэг таны зүүдийг ч мөн гэж хэлсэн. Би зүүднийхээ учрыг үнэхээр мэдэхийг хүсэж байсан учраас зөвшөөрлөө.

Даниел: Би гэр рүүгээ яваад гурван найзтайгаа хамт залбирсан. Бид их удаан залбираад дараа нь орондоо орж унтлаа. Тэгээд юу болсныг мэдэх үү? Хэн тааж чадах вэ? Тэр шөнө Их Эзэн надад хааны зүүдийг харуулсан юм. Их Эзэн хаанд нэгэн зүйл хэлэх гэж оролдож байсан болохоороо түүний зүүдэнд хэлжээ.

Би маш их гайхсан, яг тэр үед би босож сөгдөөд Их Эзэнд талархлаа.

Тэгээд хаан дээр очиж зөвхөн Их Эзэн л түүний зүүдийг мэднэ гээд зүүднийх нь тухай хэлж өглөө. Тэр нь агуу том хөшөөний тухай Их Эзэн хаанд хэлэх гэсэн юм байна лээ.

Хаан: Надад маш сайхан байлаа.

Тэгээд би Даниелд чиний Бурхан Эзэн бол Хаадын Хаан, Дээдийн Дээд гэдгийг мэдсэнээ хэлсэн. Яагаад гэвэл Их Эзэн Даниелтай хамт байсан учраас би түүнд нэгэн онцгой ажил өгсөн юм. Би түүнд талархснаа

илэрхийлж олон бэлэг өгсөн. Хамгийн гол нь би цорын ганц үнэн Их Эзэнийг мэдсэн бөгөөд тэр бол Хаадын Хаан Дээдийн Дээд юм шүү. Их Эзэний тухай надад хэлсэн Даниел чамд баярлалаа.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Та нар зүүд зүүдлэн шөнө сэрээд унтаж чадахгүй байсан үе бий юу? Тэр үед та нарт ямар байсан бэ? Небухаднезар хаан яг л тийм байсан.**

Их Эзэний тухай мэддэггүй хэн нэгэн хүнийг та нар мэддэг үү? Небухаднезар хаан Их Эзэний тухай сайн мэддэггүй байсан бөгөөд Даниел түүнд ярьж өгсөн юм. Бид Их Эзэний тухай хүмүүст ярьвал Тэр маш их баяртай байдаг. Хичээлийнхээ гол утга санааг бүгдээрээ хамтдаа давтацгаая.



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библиэ нээгээд Даниел 2:1-18; 46-49-г гарган "Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн маань энэ хэсэгт байна" гэж

хэлээд сэдвийг чангаар уншаарай.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Хэн зүүд зүүдэлсэн бэ? Хааны**

зүүдийг хэн тайлж чадахгүй байв? Харин хэн тайлж чадсан бэ? Хааны зүүдийг тайлахад нь Даниелд хэн тусалсан бэ? Хаан Даниелыг сонссоныхоо дараа Их Эзэний тухай юу гэж хэлсэн бэ? Яг Даниелын хийсэн шиг та нар ч мөн бусдад Их Эзэний тухай ярихыг хүсэж байна уу? Санагтун:



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Библиэ нээгээд Үйлс 20:24-г гарган "Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна" гэж хэлээд ишлэлийг чангаар унш. "Би Их Эзэний ивээлийн тухай сайн мэдээг хүмүүст хэлмээр байна" гэсэн ишлэлийг заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.

Хэрэгтэй зүйл:
 Библи

- Би** Өөрийгөө заах.
- Их Эзэний ивээлийн тухай** Дээшээ заах.
- сайн мэдээг** Гараа алдлан дэлгэх.
- хүмүүст** Бусдыг заах.
- хэлмээр байна.** Хуруугаа уруулдаа хүргэж дараа нь гараа бэлхүүс хүртлээ буулгах.
- Үйлс 20:24** Алгаа нийлүүлээд дэлгэнэ.



3

Хичээлээ Заах

А. Бидний Магтах Арга Зам

3x3-ын харьцаатай сүлжээг мөчир, утас, наалддаг тууз эсвэл чулуугаар хий. Дөрвөлжин тус бүр нэг тохой квадрат хэмжээтэй байна. Янз бүрийн аргаар Их Эзэнийг хүндэлж байгаа зурагнуудыг хайрцган дээр наа.

(Тэмдэглэл: Магтаал хүндлэл нь сүмд ирэхээс ч илүү чухал бөгөөд энэ нь бид Их Эзэнийг амьдралаараа хайрлаж байдгийг илэрхийлдэг юм. Ердийн шашны үйл ажиллагаа зэргээр зургаа битгий хязгаарлаарай. Бид Их Эзэний тухай хүмүүст ярьж, дуулж, сүмдээ явж, гуйлт хийж, найрсаг

байж, цэцэг арчилж, хөршөө халамжилж, амьтдыг асарч байгаа нь ч Их Эзэнийг магтан хүндэлж буй хэрэг болно).

Цаасыг бөмбөг шиг болгон базаад хүүхдүүдээр цаасан бөмбөгийг сүлжээгээр ороолгоод хэрвээ бөмбөгийг шидэхэд энэ нь зураг дээр унавал Их Эзэнийг хүмүүс хэрхэн хүндэлж байгааг асуугаарай.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Бид Их Эзэнийг хэрхэн хүндэлдэг вэ? Бид зөвхөн сүмдээ ирж, Түүнд зориулан дуулснаараа Түүнийг хүндэлдэг үү? Сүм дээр гэр бүлтэйгээ болон найз нөхөдтэйгээ Их Эзэнийг магтан хүндлэх нь сайн ч гэсэн бид хаа байгаа газраа Есүсийн тухай ярьж, Есүсийн бидэнд өгсөн зүйлүүдийг хайрлаж, хуваалцаж, хэн нэгэнд тусалж Их Эзэнийг хүндлэх нь чухал юм.**

Бид үргэлж Есүсийн тухай хүмүүст яриад байдаггүй шүү дээ. Хүмүүс бидний юу хийхийг харж байгаа. Биднийг Есүс шиг байж чадаж байгаа эсэхийг хүмүүс мэдэж байдаг. Санагтун:



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Б. Есүс Бол Миний Найз

Хэлэх: **Даниел хаанд Их Эзэний тухай ярьсан шиг бид ч мөн хүмүүст Их Эзэний тухай ярьж өгч чадна. Их Эзэний тухай бусдад хэлж өгөх ямар арга байдаг вэ? (Дуу дуулах, зураг зурах, хэн нэгний гараас хөтлөх, тэдэнтэй ярилцах гэх мэт). Есүсийн тухай бусад хүмүүс мэдэж авахад нь туслах нэгэн тоглоомыг сурцгаая.**

Есүс, Есүс. Дээшээ заах
Тэр бол миний найз. Дээшээ заагаад долоовор хуруугаа нийлүүлэх

Би эцсээ хүртэл Түүнийг магтах болно. Өөрийгөө заагаад гараа даллах

Есүс, Есүс. Дээшээ заах
Тэр танд хайртай. Дээшээ заагаад гараа зөрүүлэн цээжин дээрээ тавин хэн нэгнийг заах

Та Түүний найз болмоор байна уу? Хэн нэгнийг заагаад хоорондоо долоовор хуруугаа нийлүүлэх

Тоглоомыг хэд хэдэн удаа тоглоод сүүлийн хоёр удаа нь хүүхдүүдийг өөд өөдөөс нь харуулан зогсоогоод хооронд тоглуулаарай.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Есүсийн тухай бусдад хэлэх ямар ямар арга байдаг вэ? (Тэдэнтэй ярилцах, тэдэнд дуу дуулж өгөх, туслах, хуваалцах, тэднийг сонсох, инээмсэглэх гэх мэт). Есүс биднийг Түүний тухай бусдад ярихад баяртай байдаг. Есүсийн хайрыг хуваалцсанаараа бид Их Эзэнийг хүндэлж байдаг. Гол санаагаа хамтдаа хэлцгээе:**



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

4

Хичээлээ Хуваалцах нь

Хаалга Тогших

Юуны өмнө, хаалганы загвар зургийг (142-р хуудас) хатуу цаасан дээр хийж хүүхэд бүрт өг. Хүүхдүүдээр хаалгыг будуулж хаалганы хонх болох товчийг наалгаарай.

Хэлэх: **"Тог тог" гэдэг тоглоомонд та нар дуртай юу? Та нар үүний тухай сонсож байсан уу?** (Хэрвээ үгүй бол нэг том хүнийг туслагч болгон аваарай).

Та: "Тог тог"

Том хүн: "Хэн бэ?"

Та: "Үү, Үү"

Том хүн: "Үү гэж хэн бэ?"

Та: "Битгий уйл"

Хэлэх: **Одоо бүгдээрээ "Тог тог" тоглоомыг сурцгаая. Тэгээд та нар энэ долоо хоногт хэн нэгэнтэй энд хийсэн хаалгаа хуваалцаж болох юм. Дараах тоглоомыг зааж өгөөрэй.**

Тог, тог.

Хэн бэ?

Үү.

Үү гэж хэн бэ?

Та Есүсийн тухай мэдэх үү?

Бататгах нь

Хэлэх: **Бүгдээрээ тоглоомоо хэлэхдээ зургаа дээш нь өргөцгөөе. Та нар хоорондоо тоглоомыг давтаж болно.**

Давтах хугацаа өгөөрэй. **Есүс тэдэнд хайртай гэдгийг их олон хүмүүс мэддэггүй. Өөрийн хийсэн зүйлээ энэ долоо хоногт хэн нэгэнтэй хуваалцаад тэдэнд Есүс хичнээн хайртай болохыг нь хэлж өгөөрэй. Тэгээд гол санаагаа санацгаая:**



Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Намайг дагаад хэлээрэй.

Хэрэгтэй зүйл:

- хаалганы загвар (142-р хуудас)
- хатуу цаас
- өнгийн харандаа
- товч
- цавуу

Хичээлийн Хаалт

Хаалтын залбирлыг хэн нэгэн хүүхдээр хийлгэ. Энэ долоо хоногт хүүхэд бүрт амжилт хүсээд сурсан зүйлээ гэртээ очоод гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг нь сануулаарай.

Хааны Зүүд

Унших Зүйл

Даниел 2:1-28,46-49;
Зөнчид ба
Хаад, х. 491-502.

Цээжлэх Ишлэл

"Их Эзэний ивээлийн тухай сайн мэдээг би хүмүүст хэлмээр байна" (Үйлс 20:24).

Гол Санаа Бид Их Эзэний тухай хүмүүст ярьснаараа Түүнийг хүндэтгэдэг.

Та нар зүүд зүүдэлж байсан уу? Сэрснийхээ дараа зүүднийхээ тухай бодоход гоё байдаг уу? Эрт дээр үед нэгэн хаан их сонин зүүд зүүдэлжээ.

Небухаднезар хаан орондоо хөрвөөж их л хэцүү байлаа. Тэр нүдээ нээгээд эргэн тойрныг харав. Харанхуй хэвээр л байлаа. Хаан саяхан зүүдэлсэн хачин зүүднийхээ тухай бодсоноо эргэн унтах гэж оролдсон боловч чадсангүй.

"Мэргэдийг хурдан цуглуул" гэж тэр зарц нартаа хэлэхэд зарц нар зарим мэргэдийг сэрээн хаан дээр бушуухан авчирлаа.

Хаан Небухаднезар мэргэдэд "Би нэгэн зүүд зүүдэллээ" гэхэд мэргэд "Хаантан, мөнх наслах болтугай. Зүүдээ хэлж өгөөч тэгвэл бид танд ямар утгатай болохыг нь хэлж өгье" гэжээ.

"Үгүй ээ, та нар зүүдийг минь хэл. Тэгээд бас ямар утгатай болохыг нь ч хэл" гэж хаан хашгирлаа.

Мэргэдүүд бие бие рүүгээ харлаа. Тэдний царайнд огтхон ч инээмсэглэл тодорсонгүй. Харин "Хэн ч түүний хэлснийг хийж чадахгүй шүү дээ" гэж шивнэлдэв.

Небухаднезар хаан ихэд уурлан "Тэднийг аваад яв, бүх мэргэдийг аваад яв" гэлээ.

Мэргэдүүдийн нэг болох Даниел унтаж байтал зарц нар түүнийг сэрээж, Даниел тэднээс юу болсныг мэдэж авчээ. "Юу болоо вэ?" гэж Даниел асуухад зарц нар учрыг тайлбарлан "Хаан нэг зүүд зүүдэлжээ. Бусад мэргэдүүд үүнийг тайлж чадахгүй байна" гэв.

Даниел "Гуйж байна, намайг хаантай уулзуулаач" гэж асуув. Ингээд Даниел явсаар хааны өмнө бөхийн ёслол "Надад хугацаа өгөөч, Би Их Эзэндээ залбирч Түүнээс таны зүүдийг болон ямар утгатайг нь асуух гэсэн юм" гэхэд хаан зөвшөөрлөө.

Даниел гурван сайн найз дээрээ очоод Их Эзэнээс зүүдний нууцыг тайлахын төлөө хамтдаа залбирцгаав. Тэр шөнө Их Эзэн Даниелд хааны зүүдний утгыг нь тайлж өгөв.

Өглөө болоход Даниел Небухаднезар хаан дээр эргэн очиход хаан түүнээс "Чи миний юу

зүүдэлснийг хэлж чадах уу?" гэхэд Даниел "Үгүй, би чадахгүй. Гэвч тэнгэрт бүх нууцыг мэддэг нэгэн Эзэн Бурхан бий" гээд хаанд юу зүүдэлснийг нь болон ямар утгатайг нь хэлж өгчээ.

"Яг зөв, одоо би чиний Их Эзэн хамгийн агуу нь гэдгийг мэдлээ" гэж хаан хашгирав.

Небухаднезар хаан Даниелыг захирагч болгон мэргэдүүдийг удирдах ажил хариуцууллаа. Даниел мэргэдүүдийг хүнд байдлаас гаргасандаа баяртай байсан бөгөөд хамгийн гол нь хаан цорын ганц үнэн Их Эзэнийг мэдэж авсанд хамгийн их баяртай байлаа.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

БиӨөрийгөө заах.

Их ЭзэнийДээшээ заах.

ивээлийн тухай

сайн мэдээгГараа алдлан дэлгэх.

хүмүүстБусдыг заах.

хэлмээр байна.Хуруугаараа уруулдаа хүргэж дараа нь гараа бэлхүүс хүртлээ буулгах.

Үйлс 20:24.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Шаббат хичээл дээр хийсэн хаалгаа хөрштэйгөө эсвэл найзтайгаа хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл шинээр хаалга зурж будахад нь хүүхдэдээ туслаад дараах үгүүдийг дээр нь бичиж өгөөрэй. Дин дин, Хэн бэ?, Үү, Үү гэж хэн бэ? Та Есүсийн тухай мэдэх үү?)

Даваа

Цэцэг хайчилж эсвэл бялуу хийж, зураг зураад хөршдөө өгч тэдэнд Есүс хичнээн хайртай гэдгийг нь хэлэхэд хүүхдэдээ туслаарай.

Хүүхдийн тань бүх найзууд Есүсийг хайрлахын төлөө хүүхэдтэйгээ хамтдаа гуйгаарай.



Мягмар


Туслах, сонсох, ярилцах гэх мэт Есүсийн тухай бусдад ярьж өгөх арга замуудыг сэтгүүл болон ном сонингоос хараарай.

Бусадтай Есүсийг хуваалцах арга замуудыг хүүхдээрээ жүжиглүүлээрэй.



Лхагва

Хүүхэд тань нэгээс арвын хооронд нэг тоо бодож та тэр тоог таагаарай. Та тоог зөв таах хүртлээ хэдэн удаа алдсан бэ? Солигдоод таагаад үз. Зөвхөн Их Эзэн л бидний бодол болон зүүдийг мэдэж байдаг тухай ярилц.



Пүрэв

Даниел 2:1-28, 46-49-г хамтдаа уншаад "Хаан мэргэн хүмүүсээр юу хийлгэхийг хүссэн бэ? Тэд яагаад чадаагүй вэ? Небухаднезар хаан Их Эзэний тухай юу мэдэж авсан бэ? Бусад хүмүүс Их Эзэний тухай чамаас юу мэдэж чадах вэ?" гэж асуу.

Зүүдэлсэн зүүдийг нь хүүхдээрээ зуруулж яриулаарай. Өөрийнхөө гоё зүүднүүдээс хүүхдэдээ ярьж өг. Сайхан зүүд өгсөнд нь Есүст талархаарай.

Баасан

Гэр бүлийн залбирлын үеэр Библийн түүхийг хамтдаа жүжиглээд "Их Эзэний захиас" гэдэг тоглоом тоглоорой. Их Эзэний тухай ямар сайн зүйлийг бусдад ярьж өгөх талаар бодоод тойргоор эхлэн бие биенийхээ чихэнд шивнэж хэлээрэй.